



## **МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын захирагч  
1999-2005 он

Улаанбаатар хотод төрсөн 1964 оны 7 дугаар сарын 19-нд төрсөн. Найман нас хүртлээ ясли, цэцэрлэгт хүмүүжиж байгаад 1972 онд 48 дугаар сургуульд орж суралцсан. 1977 оноос 1 дүгээр дунд сургуульд шилжин суралцаж, 1982 онд Х.Чойбалсангийн нэрэмжит 10 жилийн лаборатори 1 дүгээр дунд сургуулийн 10 дугаар ангийг төгссөн. 1981онд МУИС-д элсэж, 1987 онд тус сургуулийг Төлөвлөгч-эдийн засагч мэргэжлээр төгссөн. 1996 онд Япон улсад Төрийн захиргааны байгууллагын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлаар, 1982 онд ХБНГУ-д Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай асуудлаар тус тус мэргэжил дээшлүүлсэн. Эдийн засгийн ухааны магистр.

1987 онд Улаанбаатар хотын Ахуйн үйлчилгээний удирдах газарт эдийн

засагч, 1989 оноос Нийтийн аж ахуйн үйлчилгээний яаманд мэргэжилтэн, 1991 оноос Улаанбаатар хотын АДХГЗ-ны Ахуйн үйлчилгээний хэлтсийн дарга, 1992 оноос Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын орлогч, 1996 оноос Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, 1997 оны 10 дугаар сараас Нийслэлийн МАХН-ын хорооны дарга, 1999 оны 1 дүгээр сараас 2006 он хүртэл Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, 2006-2007 онд Монгол Улсын Ерөнхий сайд, 2007-2012 онд Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга, 2012 оноос Монгол Улсын Их хурлын Дэд даргаар тус тус ажиллаж байна. Мөн эдгээр үндсэн үүрэгт ажлуудтай хавсран хэд хэдэн сонгуульт ажлуудыг гүйцэтгэж байв. 1999-2005, 2008-2012 онд Үндэсний их баяр наадмын зохион байгуулах хорооны даргаар 11 жил ажилласан. Энэ хугацаанд хурдан морины уралдаан нь Яармагийн дэнжид болдог байсныг болиулж, монгол даншиг наадам болдог байсан түүхт Хүй мандлын дэнжид шилжүүлж авто замыг өргөтгөн сайжруулах, шинээр зам, талбай засах, хурдан морины гарааны шинэ төхөөрөмж нэвтрүүлэх, уралдааны морьд, унаач хүүхдүүдийг даатгалд хамруулах, хамгаалалтын хувцас хэрэгслээр хангуулах, наадамчин олны тав тухыг хангах, наадамд амжилт үзүүлсэн бөхчүүд, харваачид, уяачид, унаач хүүхдүүдийн бай шагналыг тэдний хөдөлмөр зүтгэлтэй уялдуулан нэмэгдүүлэх, цолны шинэчлэл хийх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үндэсний олимпын хорооны гишүүнээр ажиллаж байх хугацаандаа 2008, 2012 оны Олимпын их наадамд оролцох Монгол Улсын шигшээ багийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, тамирчдын ахуй хангамж, бэлтгэл хангах нөхцөл байдлыг сайжруулах тал дээр онцгой анхааран, олимпын багийг ахалж ажилласнаар эдгээр хоёр олимпын их наадамд манай улсын баг тамирчид маш амжилттай оролцсон. 2010 оноос Монголын морин спорт, уяачдын холбооны ММСУХ ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан.

2005 оны ерөнхийлөгчийн сонгуульд МАХН -аас нэр дэвшин өрсөлдсөн . Сонгуулийн дараа 2005 оны 6-р сард МАХН-ын 24-р их хурал хуралдаж намын даргаар ажилласан. УИХ-ын гишүүнээр. 2008, 2012 оны УИХ-ын сонгуульд М.Энхболд Төв аймагт УИХ-ын 14-р тойрогт нэр дэвшин дахин сонгогдон ажиллаж байна.